



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ᠰᠡᠯᠡᠨᠭᠡ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠨᠢᠶᠭᠡᠮ, ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠨ  
ᠲᠠᠨᠢᠯᠴᠠᠭᠤᠯᠠ

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2019 I-X



Мэдээллийн нэгдсэн лавлах: [WWW.1212.MN](http://WWW.1212.MN)



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГЭМ  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

10 сар  
2019



## ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл.....	
АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР .....	4
1. ХҮН АМ, НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	15
1.2 ЭРҮҮЛ МЭНД .....	16
1.3 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ .....	22
1.4 ГЭМТ ХЭРЭГ .....	25
1.5 ХИЛЭЭР ОРСОН, ГАРСАН ИРГЭД.....	26
2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	27
2.1 МӨНГӨ, ЗЭЭЛ .....	27
2.2 АЙМГИЙН НЭГДСЭН ТӨСӨВ .....	29
2.3 ГАДААД ХУДАЛДАА .....	31
2.4 ҮНЭ .....	31
3. ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	
3.1 ХӨДӨӨ АЖ АХУЙ .....	36
3.2 АЖ ҮЙЛДВЭР.....	40
4. БУСАД.....	43



## Ерөнхий тэмдэглэл

- I. Товчилсон тэмдэглэлгээ:
- ГХ- Гэмт хэрэг
  - Х.н-Хэмжих нэгж
  - ХАА- Хөдөө аж ахуй
  - АҮ - Аж үйлдвэр
  - ЖДҮ- Жижиг дунд үйлдвэрлэл
  - СЭ - Сэлэнгэ
  - НХ – Нийгмийн халамж
  - ХЧТА-Хөдөлмөрийн чадвараа түр алдсан
  - ЖА-Жирэмсний амралт
  - ҮОМШӨ-Үйлдэрийн осол мэргэжлээс шалгаалах өвчин
  - НӨАТ-Нэмэгдсэн өртгийн албан татвар
  - НДШ-Нийгмийн даатгалын шимтгэл
- II. Саруудыг ромбо тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)
- III. Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-X зэргээр илэрхийлэв
- IV. Дараах тэмдэглэлийг ашиглав:
- ... Мэдээлэл байхгүй
  - Х Бүтцийн өөрчлөлт
  - 0.0 Маш бага тоо
  - +, - Зөрүү
  - Гүйцэтгэл байхгүй
  - \* Дахин
- "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.
- V. "Төл" нь төлөвлөгөө, "Гүйц" нь гүйцэтгэл
- VI. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100.0 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

**Хүн амын тоо.** Тодорхой хугацаанд, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ. Хүн амын тоог бэлэн болон суурин хүн амаар тооцдог.

**Амьд төрөлт:** Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байгааг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

**Төсөв:** Аймгийн төсвийн орлого зарлага нь төвлөрсөн төсвийн болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

**Чанаргүй зээл:** Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

**Нийгмийн даатгал:** Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

**Нийгмийн даатгалын сан:** Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчид тооцно.

**Тэтгэвэр:** Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд /хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл/-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгө байна.



**Тэтгэмж:** Хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд нийгмийн даатгалын сангаас даатгуулагчид нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

**Ажилгүйчүүд:** Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

**Үнэ:** Аймгийн төвийн захад борлогдож байгаа болон хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийг харуулна.

**Хэрэглээний үнийн индекс:** Өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

**Гэмт хэрэг:** Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүй алах хэргийг, хүүхэд гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулав.

**Хээлтэгч мал:** Нас гүйцсэн эм малыг хамруулна.

**Зүй бусаар хорогдсон малын тоонд:** Халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга, цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, худаг, хавцалд унах зэрэг хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

**Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл:** Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн:** Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.



## Сэлэнгэ аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2019 оны эхний 10 сарын байдлаар)

### 1. НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ



#### 1.1 Хүн ам

2019 оны эхний 10 сарын байдлаар манай аймагт бусад аймаг хотоос бүгд 2 286 хүн шилжин ирсэн нь өмнөх оны мөн үеэс 78 (3.3%) хүнээр буурсан үзүүлэлттэй байна. Нийт шилжин ирэгсдийн 1 128 (49.3%) нь эрэгтэйчүүд, 1 158 (50.7%) нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэйчүүдийн тоо 6 (0.5%) хүнээр өсч, эмэгтэйчүүдийн тоо 84 (6.8%) хүнээр буурсан байна.




#### 1.2 Эрүүл мэнд

Эхний 10 сарын байдлаар аймгийн хэмжээгээр нийт 1 503 эх амаржиж, 1 511 хүүхэд төрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс амаржсан эх 69 (4.8%)-өөр, амьд төрсөн хүүхэд 76 (5.3%)-аар нэмэгдсэн байна. Төрөлтийг насны бүтцээр нь харахад 25-29 насны 437 (29.1%), 20-24 насны 350 (23.2%), 30-34 насны 379 (25.2%), 35-39 насны 228 (15.2%), 40-44 насны 31 (2.1%), 45-49 насны 2 (0.1%), 20 хүртэлх насны 76 (5.1%)-ийг тус тус эзэлж байна.

Нас барсан хүний тоо 444 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 14 (3.3%) хүнээр өссөн байна. Нийт нас баралтын шалтгааны 11.3 хувь нь осол гэмтлийн, 20.6 хувь нь хорт хавдрын өвчний шалтгаантай байна. 0-1 насны хүртэлх хүүхдийн эндэгдэл 14, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 5 тохиолдол тус тус бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 11.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

#### Төрсөн эх, амьд төрсөн хүүхэд



Халдварт өвчнөөр 575 хүн өвчилж бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 96 (14.3%)-аар буурсан байна. Нийт халдварт өвчний 58.6 хувийг бэлгийн замын халдварт өвчин, 25.0 хувийг сүрьеэ, 16.4 хувийг бусад халдварт өвчин эзэлж байна.

2019 онд нийт 338 525 үзлэг хийсний 29.7 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 22.7 хувь нь гэрийн идэвхитэй үзлэг, 28.2 хувь нь диспансерийн хяналтын үзлэг эзэлж, нийт 27 183 дуудлаганд үйлчилсний 13.3 хувийг алсын дуудлагаар үйлчилж яаралтай тусламж үзүүлсэн.



### 1.3 Хөдөлмөр

2019 оны эхний 10 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 642 болсон нь өмнөх оны мөн үеэс 89 (12.2%) хүнээр буурч, өмнөх сараас 65 (9.2%) хүнээр буурсан байна. Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 642 болсны 342 (53.3%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 55.0 хувийг ерөнхий боловсролтой, 29.4 хувийг дээд боловсролтой, 11.7 хувийг мэргэжилтэй ажилчид, 3.4 хувийг тусгай дунд боловсролтой, 0.5 хувийг боловсролгүй хүмүүс эзлэх боллоо. Шинэ ажлын байранд 836 иргэн ажилд зуучлагдсаны 253 иргэн ХАА, ан агнуур, ОАА, загас агнуурын салбарт, 147 иргэн боловсруулах үйлдвэрт, 93 иргэн барилгын салбарт, 81 иргэн худалдаа, гэр ахуйн засвар, үйлчилгээний салбарт, 62 иргэн уул уурхайн салбарт, 53 иргэн захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт, 45 иргэн зочид буудал, зоогийн газрын салбарт, 27 иргэн төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагааны салбарт, 26 иргэн боловсролын салбарт, 49 иргэн бусад салбарт ажилд орсон байна.

Энэ сард бүртгэлтэй ажилгүйчүүдээс 187 хүн ажилд зуучлагдан орж, 179 хүн идэвхгүйн улмаас хасагдаж, 301 хүн шинээр бүртгэгдсэн байна.



### 1.4 Нийгмийн даатгал, халамж

2019 оны эхний 10 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 16 842 тэтгэвэр авагчдад 58 666.6 сая төгрөгийг олгосон нь өмнөх оны мөн үеэс тэтгэвэр авагчид 569 (2.8%) хүнээр өсч, олгосон тэтгэврийн хэмжээ 5 562.8 (10.5%) сая төгрөгөөр өссөн байна. Тэтгэмжийн даатгалын сангаас 6 409 хүнд 6 633.5 сая төгрөгийг ХЧТА, ЖА, оршуулга, ҮОМШӨ-ны даатгалын сангаас ҮО тэтгэвэр, ХЧТА-ны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 286 хүнд 935.6 сая төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас 476 хүнд 705.3 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгожээ.

Нийгмийн халамжийн сангаас 42 562 хүнд 12 219.2 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг олгосон нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 3 800 (9.8%) хүнээр өсч, олгосон тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ 555.5 (4.8%) сая төгрөгөөр өсчээ.






### 1.5 Гэмт хэрэг

2019 оны эхний 10 сарын байдлаар нийт 664 гэмт хэрэг бүртгэгдсэн өмнөх оны мөн үеэс 12 (1.8%)-аар өссөн байна. Нийт гэмт хэргийн 144 (21.6%) нь согтуугаар үйлдэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 (3.5%)-иар буурсан байна.

Иргэн болон байгууллагад нийт 1918.4 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеэс 495.9 (1.4дахин) сая төгрөгөөр өссөн байна. Учирсан хохирлоос 846.9 сая төгрөгийг нөхөн төлүүлж, нөхөн төлөлт 44.1 хувьтай байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 255 (40.7%) нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 223 (31.7%) нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 84 (13.2%) нь байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, 43 (6.5%) нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 59 (7.9%) нь бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 44 (7.2%) нь малын хулгай байгаа нь өмнөх оны мөн үеэс 20 (4.5%)-аар өссөн байна.

#### Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр, хувиар



### 1.6 Хилээр орсон, гарсан иргэд

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг болон Сүхбаатар боомтоор давхардсан тоогоор 567.7 мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 63.1 (10.0%) мянган хүнээр буурсан байна. Нийт зорчигчдын 442.2 (77.9%) мянга нь Монгол иргэд, 125.5 (22.1%) мянга нь гадаад иргэд байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хилээр нэвтэрсэн Монгол иргэдийн тоо 57.6 (11.5%) мянган хүнээр, гадаад иргэдийн тоо 5.5 (4.2%) мянган хүнээр буурсан үзүүлэлтэй байна.

Монгол-Оросын хилийг хялбарчилсан журмаар хил нэвтрэх эрхийн үнэмлэхээр 26 024 хүн зорчсон байна.

#### Хилээр орсон гарсан иргэд






## 2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



### 2.1 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр зээлийн өрийн үлдэгдэл 309 240.1 сая төгрөг байгаа ба үүний 2.8 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Нийт харилцахын үлдэгдэл 32 794.2 сая төгрөг, иргэдийн мөнгөн хадгаламж 100 867.6 сая төгрөг байна.

Зээлийн өрийн үлдэгдэл /тэрбум.төг/



### 2.2 Төрийн сан

2019 оны 10 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 16 924.4 сая (104.6%) төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс аймгийн төсвийн орлого 12 386.9 сая (103.1%) төгрөгийн гүйцэтгэлтэй, сумдын төсвийн орлого 4 537.4 сая (108.6%) төгрөгийн гүйцэтгэлтэй байна. 2019 оны 10 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн зарлага 71 004.4 сая (89.5%) төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлага 31 677.8 сая (85.2%), Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлага 39 326.5 сая (93.3%) төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Сумдад 10 948.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 36 578.7 сая төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, 2 257.3 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг тус тус шилжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гүйцэтгэл 316.5 сая (99.6%) төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна..

Орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, /сая.төг/






### 2.3 Гадаад худалдаа

Сэлэнгэ аймагт 2019 оны эхний 10 сарын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт 251.4 сая америк доллар, үүнээс экспорт 4.2 сая америк доллар, импорт 247.2 сая америк доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 18.1 (7.7%) сая америк доллар, үүнээс экспорт 0.8 (25.5%) сая америк доллар, импорт 17.2 (7.5%) сая америк доллараар тус тус өссөн байна.

#### Гадаад худалдааны бараа эргэлт, сая.\$




### 2.4 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 10 сард өмнөх сараас 0.2 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундаа 12.9 хувь, боловсролын үйлчилгээ 11.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш 5.1 хувь, тээвэр 2.7 хувь, гэр ахуйн тавилга гэр ахуйн бараа 1.7 хувь, тээвэр 1.1 хувь, согтууруулах ундаа тамхи мансууруулах бодис 1.0 хувь, хувцас, бөс бараа, гутал 0.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.2 хувиар буурахад амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ 3.7 хувиар, хүнсний бараа согтууруулах бус ундаа 0.7 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

#### Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны мөн үе), хувь



### Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ

Малын үнэ 2018 оны мөн үеэс 10.000-700.000 төгрөгөөр өссөн байна. Түүхий эдийн үнийн хувьд адууны шир 2.000 (5 дахин) төгрөг, үхрийн шир 2.000 (10 дахин) төгрөг тус тус буурсан байна.




### 3. ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ



#### 3.1 Хөдөө аж ахуй

2019 оны 10 дугаар сарын ургац хураалтын явцын мэдээгээр үр тариа 133.2 мян.тн, төмс 33.5 мян.тн, хүнсний ногоо 29.0 мян.тн хураан авчээ. Үүнийг 2018 оны мөн үетэй харьцуулахад үр тариа 38.0 (22.2%) мян.тонн, хүнсний ногоо 3.0 (9.3%) мян.тонн-р тус тус бага, төмс 0.5 (1.4%) мян.тонн их ургац хураан авсан байна. Аймгийн хэмжээнд 134.2 мян.тонн хадлан хураан авсан байна.

Хураан авсан үр тариа /мян.тн/




#### 3.2 Аж үйлдвэр

2019 оны эхний 10 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 416.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 421.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь урьд оны мөн үеэс үйлдвэрлэлт 81.4 (24.3%) тэрбум төгрөгөөр, борлуулалт 99.8 (31.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 269.9 (64.8%) тэрбум төгрөг нь уул уурхайн салбарт, 138.9 (33.3%) тэрбум төгрөг нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 7.6 (1.8%) тэрбум төгрөг нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт салбарт бүтээгджээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт (тэрбум төг)





## 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ



### 4.1 Цаг уур орчны мэдээ

#### ТАНЫ АНХААРАЛД

Цаг агаарын сарын урьдчилсан мэдээнд тухайн сард агаарын дундаж температур болон орох хур тунадасны хэмжээ нь олон жилийн дундажтай харьцуулахад ямар байхыг баруун (Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор), төв (Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул), зүүн (Хэнтий, Дорнод, Сүхбаатар), говийн (Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говь-Сүмбэр) нутгийн гэсэн **4 бүс** нутаг тус бүрээр ялган зааж өгдөг. Түүнчлэн хэдий үед нутгийн аль хэсэгт дулаарах, хүйтрэх, бороо, цас орох, салхи шуурга болохыг тусгана. Цаг агаарын үзэгдэл нутгийн **30 хувиас** хэтрэхгүйгээр зурвас газраар ажиглагдах тохиолдолд “зарим газраар”, **30-70 хувьд** “ихэнх нутгаар”, **70 хувиас дээш** нутгийг хамрах тохиолдолд “бүх нутгаар” гэсэн нэр томъёо хэрэглэдэг. Дулааны улиралд агаарт болон хөрсний гадарга дээр температур **00**-аас бага болж хүйтрэхийг “очир хүйтрэл” гэнэ.

Цаг агаарын урьдчилсан мэдээг өдөр бүр 12 цагаар болон нэг, тав хоногоор нарийвчлан гаргаж радио, телевиз, хэвлэлээр нийтэд мэдээлдэг. Цаг агаарын байдал эрс өөрчлөгдөн цаашид хөдөө аж ахуйн болон эдийн засгийн бусад салбарын хэвийн үйл ажиллагаанд саад хийхээр аюултай үзэгдлийн хэмжээнд хүрч болзошгүй тохиолдолд “Урьдчилан анхааруулах мэдээ”, “Урьдчилан сэрэмжлүүлэх мэдээ” гаргаж радио, телевизээр нийт ард иргэдэд, харин ноцтой бэрхшээл учруулж эд хөрөнгө, иргэдийн амь нас хохирохоор онц аюултай үзэгдлийн хэмжээнд хүрэхээр бол “Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ” гаргаж “Харанга” дохиотойгоор мэдээлэх ба мэдээллийг онцгой байдлын шугамаар нийт ард иргэд, төр засгийн бүх шатны удирдлагад яаралтай хүргэдэг. Засаг дарга нар “Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ”-г хүлээн авмагц мэдээллийг өөрийн харъяа нутаг дэвсгэрийн иргэдэд хүргэх, гамшгаас хамгаалах, гамшгийн голомтод ажиллах, сэргээн босгох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах үүрэгтэй.

Ус, цаг агаарын гамшигт үзэгдлийн улмаас хүний амь нас эрсдсэн, байгаль орчин, эд хөрөнгөнд хохирол учирсан тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга ажлын хэсэг томилон ажиллуулж, уг гамшигт үзэгдлээс хамгаалах талаар зохион байгуулсан арга хэмжээ, үр дүн, учирсан хохирол, гарсан зардлын талаархи мэдээллийг нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой байдлын газар, хэлтэс, Улсын онцгой байдлын ерөнхий газарт, аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв Ус цаг уурын хүрээлэнд 3 хоногийн дотор тус тус ирүүлнэ. Цаг агаарын мэдээний талаар лавлах, эсвэл байгаль цаг уурын сонин хачин үзэгдлийн талаархи мэдээллийг Улаанбаатар хотын 326606, **326609** утсаар өгөх юмуу “УБ-46, Жуулчны гудамж-5, Ус цаг уурын хүрээлэнгийн “Урьдчилан мэдээлэх сектор” гэсэн хаягаар ирүүлнэ.

#### Уур амьсгалын тойм

##### *Climate review*

Уур амьсгалын дунджаар агаарын температурын сарын дундаж нь манай аймгийн нутгаар 8-13 градус хүйтэн байдаг. Гэвч зарим жил энэ утгаас нийлээд хазайдаг. Тухайлбал: 1988, 1990, 1994, 1995, 1999, 2001, 2005-2008 онд ихэнх сумдын нутгаар олон жилийн дунджаас 1-3 градусаар дулаан байсан ба өдрийн үнэмлэхүй их температур 5-10 градус хүрч дулаарсан бол 1986, 1987, 1993, 1996, 2000, 2002, 2003, 2009, 2012 онд ихэнх сумдын нутгаар олон жилийн дунджаас 1-6 градусаар хүйтэн байсан бөгөөд 2000 онд үнэмлэхүй бага температур 28-33 градус хүрч хүйтэрч байв.

Энэ сард нутгийн баруун хэсгээр 4-7 мм хур тунадас ордог боловч жил бүр харилцан адилгүй. Тухайлбал: 1980, 2000, 2002, 2003 онд 1-3 дахин их цас орсон бол 1988, 1995, 1997, 1999, 2004-2008 онд ихэнх сумдын нутгаар дунджаас бага цас оржээ.



Олон жилийн дунджаар ихэнх сумдын нутгаар 2-8 см зузаан цас тогтдог боловч цас их орсон жил 20 см хүрдэг. Цасан шуурга жил бүр 2-5 удаа, зарим жил 6-8 удаа ажиглагддаг. Салхи 15 м/с-ээс хүчтэй болох тохиолдол 2-3 удаа ажиглагддаг. Сүүлийн жилүүдэдажиглагдсан салхины үнэмлэхүй их хурд 1991 онд ихэнх сумдын нутгаар 18-28 м/с хүчтэй шороон болон цасан шуурга шуурч байжээ.

## ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

### Weather forecast

Агаарын температурын сарын дундаж нь 8-13 градус хүйтэн байдаг бөгөөд энэ сард олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй байна /1 дүгээр зураг/.


Нэгдүгээр арав хоногийн эхний хагаст шөнөдөө 9-14 градус хүйтэн, өдөртөө 1 градус хүйтнээс 4 градус дулаан байх төлөвтэй байна. Нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн сүүлчээр бага зэрэг хүйтэрч Орхон, Сэлэнгэ, Ерөө голуудын сав дагуух нутгаар шөнөдөө 26-31 градус өдөртөө 14-19 градус хүйтэн, бусад сумдын нутгаар шөнөдөө 22-27 градус, өдөртөө 13-18 градус хүрч хүйтрэх төлөвтэй.

Энэ сард олон жилийн дунджийн орчим цас орох төлөвтэй /2 дугаар зураг/.


Нэгдүгээр арав хоногийн дунд ба сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр, гуравдугаар арав хоногийн сүүлчээр зарим сумдын нутгаар цас орох төлөвтэй.

Салхи нэг болон хоёрдугаар арав хоногийн дунд болон сүүлчээр, гуравдугаар арав хоногийн сүүлчээр зарим сумдын нутгаар 16-18 м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.

### 11-р сарын агаарын температурын урьдчилсан мэдээ



### 11-р сарын хур тунадасны урьдчилсан мэдээ



## 5. БУСАД

### а . Хяналт шалгалт

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2019 оны эхний 10 сарын байдлаар 1 529 аж ахуйн нэгж байгууллага, 310 иргэнд хяналт, шалгалт хийж, 3 481 зөрчил дутагдал илрүүлж, 1 751 зөрчил арилгуулсан байна.

### б. Онцгой байдлын газрын мэдээ

Сэлэнгэ аймгийн хэмжээнд он гарсаар 553 объект, 17 айл өрх үзлэг шалгалтанд хамрагдаж, 1 943 зөрчил илрүүлэн, 650 зөрчил дутагдлыг арилгуулсан байна. 2019 оны



эхний 10 сарын байдлаар объектод 112, ой хээрийн 16 гал түймэр гарч 469.2 сая төгрөгийн хохирол учирсан байна.

**в. Түүвэр судалгаа**


2019 оны эхний 10 дугаар сарын байдлаар Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг 340 өрхөөс, Ажиллах хүчний судалгааг 540 өрхөөс авч, судалгаанд хамрагдсан өрхүүдэд урамшуулал болгон 3 320.0 мянган төгрөг олгоод байна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА Д.ГҮНДЭГМАА

**1. ХҮН АМ, НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ****1.1 ХҮН АМ****1.1.1 ШИЛЖИЖ ИРСЭН ИРГЭДИЙН ТОО, сумдаар**

Сумын нэр	2016 I-X	2017 I-X	2018 I-X		2019 I-X	
			Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Дүн	1 211	1 275	2 364	1 242	2 286	1 158
Алтанбулаг	52	61	33	17	35	21
Ерөө	55	87	104	53	121	56
Зүүнбүрэн	30	39	65	37	52	23
Мандал	218	252	876	480	737	368
Орхон	21	22	38	16	34	14
Сант	25	31	49	24	67	31
Цагааннуур	43	40	58	33	78	43
Баянгол	63	88	121	56	177	89
Сайхан	167	137	322	159	370	183
Орхонтуул	39	47	62	34	52	26
Баруунбүрэн	25	40	65	35	87	48
Шаамар	33	57	79	39	86	49
Хүдэр	31	32	37	18	58	27
Сүхбаатар	309	279	352	186	211	121
Жавхлант	39	24	27	15	39	20
Түшиг	33	10	32	17	40	21
Хушаат	28	29	44	23	42	18

Эх үүсвэр: Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

**Шилжиж ирсэн иргэдийн тоо**

**1.2 ЭРҮҮЛ МЭНД****1.2.1 ТӨРӨЛТ**

Сумын нэр	төрсөн эх				2019 I-X
	2016 I-X	2017 I-X	2018 I-X	2019 I-X	2018 I-X
<b>ДҮН</b>	<b>1 557</b>	<b>1 417</b>	<b>1 434</b>	<b>1 503</b>	<b>104.8</b>
Алтанбулаг	1	2	2		
Ерөө	51	34	47	35	74.5
Зүүнбүрэн	7	3	4	3	75.0
Мандал	514	504	496	539	108.7
Орхон				1	
Сант					
Цагааннуур	6	13	15	8	53.3
Баянгол	2	4	3	2	66.7
Сайхан	99	76	87	70	80.5
Орхонтуул	7	5	8	3	37.5
Баруунбүрэн	6	2	9	2	22.2
Шаамар	1	1	2	2	100.0
Хүдэр	3	4	2	2	100.0
Сүхбаатар	836	755	747	819	109.6
Жавхлант		1	1	2	2.0*
Түшиг	20	13	10	15	150.0
Хушаат	4		1		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.2 АМЬД ТӨРСӨН ХҮҮХДИЙН ТОО**

Сумын нэр	амьд төрсөн хүүхэд								2019 I-X 2018 I-X
	2016 I-X		2017 I-X		2018 I-X		2019 I-X		
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	
<b>Бүгд</b>	<b>1 565</b>	<b>747</b>	<b>1 424</b>	<b>689</b>	<b>1 435</b>	<b>686</b>	<b>1 511</b>	<b>712</b>	<b>105.3</b>
Алтанбулаг	1	1	2	1	2				
Ерөө	51	25	35	18	49	25	36	16	73.5
Зүүнбүрэн	7	3	3	2	3	2	3	1	100.0
Мандал	522	237	509	239	496	238	543	250	109.5
Орхон							1		
Сант									
Цагааннуур	6	2	12	7	15	7	8	4	53.3
Баянгол	2	0	4	2	3		2	1	66.7
Сайхан	99	62	76	39	86	40	70	29	81.4
Орхонтуул	7	6	5	2	8	2	3	2	37.5
Баруунбүрэн	6	3	2	2	8	6	2		25.0
Шаамар	1	1	1		2	1	2		100.0
Хүдэр	3	3	4	2	2	1	2		100.0
Сүхбаатар	836	397	757	368	748	355	822	402	109.9
Жавхлант			1	1	1		2		2.0*
Түшиг	20	7	13	6	11	9	15	7	136.4
Хушаат	4	0			1				

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.3 ТӨРСӨН ЭХ, боловсролоор**

үзүүлэлт	2016 I-X	2017 I-X	2018 I-X	2019 I-X	<u>2019 I-X</u> 2018 I-X
<b>Бүгд</b>	<b>1 557</b>	<b>1 417</b>	<b>1 434</b>	<b>1 503</b>	<b>104.8</b>
дээд боловсрол	297	322	334	369	110.5
мэргэжлийн болон техникийн боловсрол	66	73	60	74	123.3
дунд боловсрол	1082	920	965	953	98.8
бага боловсрол	86	83	59	73	123.7
боловсролгүй	26	19	16	34	2.1*

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.4 ТӨРСӨН ЭХ, насны бүлгээр**

үзүүлэлт	2016 I-X	2017 I-X	2018 I-X	2019 I-X	<u>2019 I-X</u> 2018 I-X
<b>Бүгд</b>	<b>1 557</b>	<b>1 417</b>	<b>1 434</b>	<b>1 503</b>	<b>104.8</b>
20 хүртэлх	104	98	71	76	107.0
20 - 24	433	358	365	350	95.9
25 - 29	476	435	445	437	98.2
30 - 34	304	307	311	379	121.9
35 - 39	193	183	203	228	112.3
40 - 44	46	36	37	31	83.8
45 - 49	1		2	2	100.0

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.5 НАС БАРАЛТ**

Сумын нэр	нас баралт								<u>2019 I-X</u> 2018 I-X
	2016 I-X		2017 I-X		2018 I-X		2019 I-X		
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	
<b>Бүгд</b>	<b>475</b>	<b>192</b>	<b>406</b>	<b>159</b>	<b>430</b>	<b>161</b>	<b>444</b>	<b>174</b>	<b>103.3</b>
Алтанбулаг	23	14	17	7	25	6	22	5	88.0
Ерөө	39	8	34	10	26	6	34	7	130.8
Зүүнбүрэн	13	7	8	3	11	4	12	3	109.1
Мандал	105	36	102	34	123	53	97	45	78.9
Орхон	8	7	9	3	12	2	6	1	50.0
Сант	8	3	8	3	5	2	13	6	2.6*
Цагааннуур	24	6	19	8	18	8	16	7	88.9
Баянгол	20	6	19	7	7	4	13	3	2.0*
Сайхан	38	18	30	12	34	14	40	19	117.6
Орхонтуул	17	10	14	10	12	3	15	4	125.0
Баруунбүрэн	14	4	11	5	10	5	18	10	180.0
Шаамар	23	13	18	9	19	9	18	7	94.7
Хүдэр	13	5	11	1	9	4	5	1	55.6
Сүхбаатар	113	45	95	45	93	31	116	47	124.7
Жавхлант	6	1	5	1	10	6	5	2	50.0
Түшиг	7	5	3	0	9	2	6	4	66.7
Хушаат	4	4	3	1	7	2	8	3	114.3

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.6 НАС БАРАЛТ, насы бүлгээр**

үзүүлэлт	2016 I-X	2017 I-X	2018 I-X	2019 I-X	<u>2019 I-X</u> <u>2018 I-X</u>
<b>Бүгд</b>	<b>475</b>	<b>406</b>	<b>430</b>	<b>444</b>	<b>103.3</b>
эмэгтэй	192	145	161	174	108.1
0 - 1	23	12	14	14	100.0
1 - 5	8	5	3	5	166.7
6 - 18	13	7	9	5	55.6
19 - 54	153	134	118	118	100.0
54+	278	248	286	302	105.6

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.7 НЯЛХСЫН ЭНДЭГДЭЛ**

Сумын нэр	0-1 насны хүртэлх хүүхэд			
	2016 I-X	2017 I-X	2018 I-X	2019 I-X
<b>Дүн</b>	<b>23</b>	<b>12</b>	<b>14</b>	<b>14</b>
Алтанбулаг		1		
Ерөө	2	2		
Зүүнбүрэн			1	
Мандал	5	3	2	1
Орхон				
Сант				
Цагааннуур	1	2		1
Баянгол		1		
Сайхан	1		1	3
Орхонтуул				
Баруунбүрэн	1			1
Шаамар	1			
Хүдэр				
Сүхбаатар	12	3	10	8
Жавхлант				
Түшиг				
Хушаат				

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



Сумын нэр	1-5 насны хүүхэд			
	2016 I-X	2017 I-X	2018 I-X	2019 I-X
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>12</b>	<b>3</b>	<b>5</b>
Алтанбулаг		1		
Ерөө		2		
Зүүнбүрэн				
Мандал	2	3	1	1
Орхон				
Сант	1			
Цагааннуур		2		
Баянгол				
Сайхан		1		1
Орхонтуул				
Баруунбүрэн				
Шаамар	1			
Хүдэр				
Сүхбаатар	3	3	1	2
Жавхлант			1	
Түшиг				
Хушаат				1

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Үзүүлэлт	Нас барсан хүний тоо				<u>2019 I-X</u> 2018 I-X
	2016 I-X	2017 I-X	2018 I-X	2019 I-X	
<b>Дүн</b>	<b>475</b>	<b>406</b>	<b>430</b>	<b>444</b>	<b>103.3</b>
Зүрх судасны тогтолцооны өвчин	184	158	167	192	115.0
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	54	57	51	50	98.0
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	49	42	35	31	88.6
Амьсгалын тогтолцооны өвчин	13	15	18	17	94.4
Хавдар	117	104	126	111	88.1
Бусад	58	30	33	43	130.3

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.8 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГСӨД**

Сумын нэр	бүх халдварт өвчин				2019 I-X
	2016 I-X	2017 I-X	2018 I-X	2019 I-X	2018 I-X
<b>ДҮН</b>	<b>1 654</b>	<b>530</b>	<b>671</b>	<b>575</b>	<b>85.7</b>
Алтанбулаг	56	31	54	35	64.8
Ерөө	96	19	28	20	71.4
Зүүнбүрэн	26	23	10	11	110.0
Мандал	550	78	100	120	120.0
Орхон	9	3	10	4	40.0
Сант	15	1	1	1	100.0
Цагааннуур	74	29	29	21	72.4
Баянгол	28	7	37	12	32.4
Сайхан	138	24	37	33	89.2
Орхонтуул	11	8	9	9	100.0
Баруунбүрэн	22	1	3	2	66.7
Шаамар	56	37	24	22	91.7
Хүдэр	49	14	11	2	18.2
Сүхбаатар	458	238	280	243	86.8
Жавхлант	26	3	10	11	110.0
Түшиг	10	9	25	10	40.0
Хушаат	30	5	3	19	6.3*

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Сумын нэр	бэлгийн замын өвчин				2019 I-X
	2016 I-X	2017 I-X	2018 I-X	2019 I-X	2018 I-X
<b>ДҮН</b>	<b>320</b>	<b>276</b>	<b>457</b>	<b>337</b>	<b>73.7</b>
Алтанбулаг	20	15	42	15	35.7
Ерөө	10	4	11	7	63.6
Зүүнбүрэн	9	9	9	7	77.8
Мандал	49	38	63	63	100.0
Орхон			9	3	33.3
Сант	1	1	1	1	100.0
Цагааннуур	17	17	22	13	59.1
Баянгол			23	3	13.0
Сайхан	14	8	33	16	48.5
Орхонтуул	2	3	5	3	60.0
Баруунбүрэн	10			1	
Шаамар	14	22	14	17	121.4
Хүдэр	4	6	2		
Сүхбаатар	158	144	198	166	83.8
Жавхлант	3	2	6	10	166.7
Түшиг	5	6	19	9	47.4
Хушаат	4	1		3	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



Сумын нэр	гипатит				2019 I-X
	2016 I-X	2017 I-X	2018 I-X	2019 I-X	2018 I-X
<b>ДҮН</b>	<b>6</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>3</b>	150.0
Алтанбулаг			1	1	100.0
Ерөө					
Зүүнбүрэн					
Мандал	3				
Орхон					
Сант					
Цагааннуур					
Баянгол					
Сайхан					
Орхонтуул					
Баруунбүрэн					
Шаамар				1	
Хүдэр	1				
Сүхбаатар	1			1	
Жавхлант	1				
Түшиг					
Хушаат			1		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Сумын нэр	сүрьеэ				2019 I-X
	2016 I-X	2017 I-X	2018 I-X	2019 I-X	2018 I-X
<b>ДҮН</b>	<b>166</b>	<b>159</b>	<b>135</b>	<b>144</b>	<b>106.7</b>
Алтанбулаг	11	12	7	15	2.1*
Ерөө	3	10	14	10	71.4
Зүүнбүрэн	1			4	
Мандал	45	36	33	46	139.4
Орхон	4	3	1	1	100.0
Сант	1				
Цагааннуур	5	12	6	5	83.3
Баянгол	12	7	13	9	69.2
Сайхан	15	10	4	12	3.0*
Орхонтуул	7	5	3	6	2.0*
Баруунбүрэн	1	1	2	1	50.0
Шаамар	6	2	6	2	33.3
Хүдэр	2	3	5	2	40.0
Сүхбаатар	53	52	31	28	90.3
Жавхлант			4	1	25.0
Түшиг		3	5	1	20.0
Хушаат		3	1	1	100.0

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.3 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ****1.3.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД, боловсролоор**

Үзүүлэлт	2016 I-X	2017 I-X	2018 I-X	2019 I-X	<u>2019 I-X</u> 2018 I-X
<b>Бүгд</b>	<b>764</b>	<b>895</b>	<b>731</b>	<b>642</b>	<b>87.8</b>
-Үүнээс эмэгтэй	374	465	419	342	81.6
-дээд	214	308	204	189	92.6
-тусгай дунд	42	64	53	22	41.5
-ерөнхий боловсролтой	405	379	348	353	101.4
-мэргэжилтэй ажилчид	100	136	118	75	63.6
-боловсролгүй	3	8	8	3	37.5

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

**1.3.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, сумдаар**

Сумын нэр	Сарын эхний ажилгүйчүүд	Тухайн сард хасагдсан		Нэмэгдсэн	Сарын эцэс
		Ажилд зуучлагдсан	Идэвхгүйн улмаас хасагдсан		
<b>ДҮН</b>	<b>707</b>	<b>187</b>	<b>179</b>	<b>301</b>	<b>642</b>
Алтанбулаг	49	14	1	5	39
Ерөө	26			1	27
Зүүнбүрэн	38				38
Мандал	119	22	24	46	119
Орхон	3	7	1	11	6
Сант	20	5	8	8	15
Цагааннуур	40	2	3	12	47
Баянгол	60	29	13	24	42
Сайхан	33	4	24	31	36
Орхонтуул	41	12	1	12	40
Баруунбүрэн	0	24		24	0
Шаамар	24	2	10	4	16
Хүдэр	15	3	7	6	11
Сүхбаатар	213	63	86	116	180
Жавхлант	4		1		3
Түшиг	17			1	18
Хушаат	5				5

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

**1.3.3 ШИНЭ АЖЛЫН БАЙР**

	Бүгд	ХАА, ан агнуур, ОАА, загас агнуур	Уул уурхай, олборлох үйлдвэр	Боловсруулах үйлдвэр	Цахилгаан, дулаан, усан хангамж	Барилга	Худалдаа, гэр ахуйн засвар, үйлчилгээ	Зочид буудал, зоогийн газар	Тээвэр, холбоо	Санхүүгийн үйл ажиллагаа	мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа	Боловсрол	Эрүүл мэнд, нийгмийн халамж	урлаг, үзвэр, үйлчилгээний бусад үйл ажиллагаа
<b>ДҮН</b>	<b>836</b>	<b>253</b>	<b>62</b>	<b>147</b>	<b>2</b>	<b>93</b>	<b>81</b>	<b>45</b>	<b>7</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>53</b>	<b>27</b>	<b>26</b>	<b>12</b>	<b>20</b>
Алтанбулаг	23	6		8		2	2	2					2		1	
Ерөө	60	8	41	2			4						3	1		1
